



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 20 өдөр

Дугаар А/594

Булган сум

┌ Могод сумын Засаг даргын Тамгын газарт ┐
дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” тушаалын 2.1.1 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 09 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Могод сумын Баясгалант багийн Хүйтний гол гэх газарт малын гоц халдварт цэцэг өвчин оношлогдсон тул Могод сумын Засаг даргын Тамгын газарт 14,000,000 (арван дөрвөн сая) төгрөгийн дэмжлэгийг олгосугай.

2.Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

3.Хонины цэцэг өвчний голомтод хорио цээрийн үед авах арга хэмжээг мэргэжлийн байгууллагатай хамтран шуурхай хэрэгжүүлж ажиллахыг Могод сумын Засаг дарга (Б.Мөнхбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ